



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/574

Хэрлэн сум


Ажил гүйцэтгэх гэрээний төлбөрт
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Аравдугаар хуралдааны “Гучин сая мод” хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 07 дугаар тогтоол, 2023 оны Хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг мэдээлэх, сурталчилах, иргэд олон нийт, хүүхэд залууст мод тарьж ургуулах, арчлах, хамгаалах ажилд сургах, ач холбогдлыг таниулах, экологийн боловсрол олгох зорилгоор пэйж хуудас хөтөлж мэдээ мэдээлэл, контент, нэвтрүүлэг бэлтгэх ажил үйлчилгээг гүйцэтгэж буй “Зүрхэн нутгийн дуу хоолой” ТББ-ын гэрээний төлбөрт 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ